



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/100

Есөнбулаг сум

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1. дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь хэсэг, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь хэсэг, Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Оргил, Жинст багуудын нутаг дэвсгэрт удаа дараалан гарч буй ариутгах татуургын шугам сүлжээний бөглөрлийн шалтгаан, эх үүсвэрийг тодорхойлж, инженерийн шийдэл гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

- | | | |
|-----------------------|--------------|--|
| Ажлын хэсгийн дарга: | Э.Пүрэвжав | (Есөнбулаг сумын Засаг даргын орлогч) |
| Гишүүдэд: | М.Батсуурь | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Зөвлөх инженер, Монгол Улсын зөвлөх инженер) |
| | Г.Золзаяа | (Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч) |
| | Б.Өрнөхбаяр | (Стандарт хэмжилзүйн хэлтсийн Итгэмжлэгдсэн сорилтын нэгдсэн лабораторийн эрхлэгч) |
| | Г.Хүрэлхүү | ("Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер) |
| | Д.Байгальмаа | ("Ундарга-Алтай" аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ашиглалтын инженер) |
| Нарийн бичгийн дарга: | М.Мөнхцэцэг | (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн) |

2.Ариутгах татуургын шугам сүлжээний шугамын трассын дагуу шалгаж, гэмтлийг илрүүлэн, инженерийн шийдэл гаргаж, холбогдох арга хэмжээ авч, үр дүнг 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг (Э.Пүрэвжав)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ